ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ
ЗУРАГ ТӨСЛИЙН БАРИМТ БИЧГИЙН
МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

2025 оны 12 дугаар сарын 25 өдөр

Дугаар 396/2025

Улаанбаатар-16100
Утас: 70001150
Факс: 70007636

Объектын нэр:	Улаанбаатар-Мандалговь А0201 чиглэлийн замаас Сэргэлэн сум А25 чиглэлийн авто зам хүртэлх хатуу хучилттай авто замын инженерийн нарийвчилсан зураг төсөл
Объектын байршил:	Төв аймаг, Сэргэлэн сум
Хүчин чадал:	12.662 км, 1.286 км, 24 у/м, 48.95 у/м
Захиалагч:	Сэргэлэн сумын Засаг даргын тамгын газар
Санхүүжилтийн эх үүсвэр:	Улс, орон нутгийн төсөв
Зураг төслийн ерөнхий гүйцэтгэгчийн нэр,	"Эм Ай Эл" ХХК
Регистрийн дугаар:	5568501
Тусгай зөвшөөрлийн хүчинтэй байх хугацаа:	2030.04.10
Зураг төсөл боловсруулах үндэслэл:	
Зураг төсөл боловсруулах даалгавар, баталсан албан тушаалтан, дугаар, огноо:	Төв аймгийн Засаг даргын 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдөр баталсан Улсын чанартай А0201 чиглэлийн замаас Сэргэлэн сумын чиглэлийн авто зам хүртэлх хатуу хучилттай авто замын ажлын зураг төсөл боловсруулах даалгавар, №07
Зураг төсөл боловсруулах гэрээ, дугаар, огноо, гэрээний дүн	Сэргэлэн сумын Засаг даргын Тамгын газар болон "Эм Ай Эл" ХХК-ийн хооронд 2025 оны 06 сарын 02-ны өдөр байгуулсан авто замын зураг төсөл боловсруулах гэрээ, №:ТӨАСЭС3ДТГ/20250103021

Техникийн нөхцөл:

Техникийн нөхцөл	Олгосон байгууллага	Дугаар, огноо	Хүчинтэй байх хугацаа
Газрын шилэн кабелийг шилжүүлэх, хамгаалах	"Жемнэт" ХХК	2025.06.16	1 жил
Мэдээлэл, харилцаа холбооны шилэн кабель хамгаалах, шилжүүлэх	"Мэдээлэл холбооны сүлжээ" ХХК	ШК-202506/04 2025.06.16	1 жил
Шилэн кабелийг шилжүүлэн, хамгаалах	"Скайнэтворкс" ХХК	№10/25 2025.06.19	1 жил
Цахилгаан дамжуулах шугам, дэд станц зөөх	"Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК	№01/03284/25 2025.07.24	1 жил

Зөвшилцсөн байгууллага:

Төв аймгийн Засаг дарга	Л.Төмөрчөдөр
Төв аймгийн Ерөнхий архитектор	Д.Алтансүх
Төв аймгийн Засаг даргын тамгын газрын Хөрөнгө оруулалт, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга	Э.Уянга
Төв аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга	Б.Насанжаргал
Төв аймгийн Замын цагдаагийн тасгийн дарга, Цагдаагийн ахмад	Н.Сундуйжав
Сэргэлэн сумын Засаг дарга	Т.Гансүх
Сэргэлэн сумын Газрын даамал	Р.Жавзандолгор

Зураг төслийн бүрэлдэхүүн:

Зургийн бүрдэл:	Зураг төслийг гүйцэтгэсэн байгууллагын нэр:	Шалгасан экспертийн нэр:
Авто замын инженерийн нарийвчилсан зураг төсөл	"Эм Ай Эл" ХХК	С.Батсүх
Тайлбар бичиг		
Техникийн шаардлага		
Авто зам, гүүрийн барилгын ажлын төсөв		Л.Батхүү

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР ЭХ ХУВЬ

1625941156

Гүүрийн зураг төсөл		С.Хаснавч
Ус зүйн судалгааны тайлан		Л. Дашдорж
Геодезийн тайлан	"Модун Артель групп" ХХК	-
Геологийн судалгааны тайлан /Барилгын хөгжлийн төвөөр 2025.06.27-ний өдөр магадлал хийсэн байна.	"Инж Гео Тех" ХХК Архив-06-2025-045	-
Цахилгааны шугам, дэд станц зөөх ажлын зураг төсөл	"Пи Юу Ай" ХХК	Ч.Наранцэцэг
Цахилгааны шугам, дэд станц зөөх ажлын төсөв		Г.Болормаа
Холбооны шугам шилжүүлэх, хамгаалах ажлын зураг төсөл	"Пи Юу Ай" ХХК	Д.Балмаа
Холбооны шугам шилжүүлэх, хамгаалах ажлын төсөв		Г.Гантуяа

Ерөнхий дүгнэлт:

Авто зам, замын байгууламжийн чигийн сонголт болон техник-эдийн засгийн үзүүлэлтүүд, зураг төслийн үндсэн төлөвлөлт, шийдэл, хучилтын бүтээцийн талаарх дүгнэлт	**Авто зам, замын байгууламжийн төлөвлөлт, хүчин чадал:** **Авто замын ангилал:** (**Гол зам - 1В-ОЗГЗ-ЗХН-4-100** Тэв замын сүлжээн дэх олон зурваст гол зам бөгөөд зорчих хэсэг нь зааглагдсан, хөдөлгөөний **4** зурвастай, тооцоот хурд нь 100км/цаг) Тусгаарлах зурвас 8.0 м Авто замын зорчих хэсгийн өргөн 4х3.75 м, бэхэлгээтэй хөвөөний өргөн 4х1.0 м, тусгаарлах зурвасын өргөн 8.0 м, ногоон байгууламжийн өргөн 2х3.0 м, явган хүний замын өргөн 2х2.0 м, тусгаарлах зурвасын өргөн 2х0.5 м, дугуйн замын өргөн 2х2.0 м, хөвөөний өргөн 2х1.0 м **Сэргэлэн сум (Холбоос зам 2А-Хрз-ЗХГ-2-80 ангиллын Хуримтлуулагч зам)** Хөдөлгөөний 2 зурвастай, зорчих хэсэг нь зааглагдаагүй, тооцоот хурд 80км/цаг Авто замын зорчих хэсгийн өргөн 7.0 м, ногоон байгууламжийн өргөн 2х1.5 м, дугуйн замын өргөн 2х1.5 м, тусгаарлах зурвасын өргөн 2х0.5 м, явган хүний замын өргөн 2х1.5 м, хайрган хөвөөний өргөн 2х1.0 м **Авто замын хучилтын хийц:** Өнгө асфальтбетон хучилт 50 мм Суурь асфальтбетон хучилт 50 мм Буталсан чулуун суурь 300 мм Суурийн доод үе 300 мм **Явган хүний зам, дугуйн замын хучилтын хийц:** Өнгө асфальтбетон 50 мм Буталсан чулуун суурь 150 мм Суурийн доод үе 300 мм <u>48 у/м төмөрбетон гүүр:</u> Гүүрийн өргөн 2х14.54 у/м, тусгаарлаг зурвасын өргөн 7.2 м, Гүүрийн зорчих хэсгийн өргөн 4х3.75 м, аюулгүйн зурвасын өргөн 2х2.0 м, дугуйн замын өргөн 2х2.0 м, явган хүний замын өргөн 2х2.25 м, <u>24 у/м төмөрбетон гүүр:</u> Гүүрийн зорчих хэсгийн өргөн 8 м, явган хүний замын өргөн 2х3.0 м, **Гүүрийн хучилтын хийц:** Асфальтбетон хучилт 50 мм Хамгаалалтын армтурласан бетон үе 40 мм Ус тусгаарлах үе 10 мм Тэгшилгээний бетон 30 мм Хучилтын хавтан 220 мм
Боловсруулсан зураг төслийн сонгосон шийдэл, магадлалын явцад хийсэн нэмэлт, өөрчлөлтөөс шалтгаалах үр	Орон тооны бус экспертийн дүгнэлтийн дагуу зураг төсөлд холбогдох засвар, өөрчлөлтүүдийг оруулж дахин хянуулан баталгаажуулсан байна. Үүнд: <u>Зураг төсөлд:</u>

ТӨРИЙН ӨМЧИТ ТИЛДЭРИЙН ГАЗАР
ЭХ ХУВЬ
Ө.Оюун
25 12 25

дүнгийн талаарх тодорхой санал, дүгнэлт:	Авто замын зураг төсөлд /2025 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн дүгнэлт/ Гүүрийн зураг төсөл /2025 оны 12 дугаар сарын 24-ны өдрийн дүгнэлт/ Ус зүйн сулдалгааны ажлын тайланд /2025 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн дүгнэлт/ Гэрэлтүүлгийн зураг төсөлд /2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн дүгнэлт/ Холбооны зураг төсөлд /2025 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн дүгнэлт/ <u>Төсөвт:</u> Авто замын барилгын ажлын төсөвт /2022 оны 12 дугаар сарын 25-ний өдрийн дүгнэлт/ Гэрэлтүүлгийн төсөвт /2022 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн дүгнэлт/ Холбооны төсөвт /2025 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн дүгнэлт/ Дээрх дүгнэлтүүд нь магадлалын ерөнхий дүгнэлтийн хавсралт болно.
Зураг төслийн талаар явуулж байгаа төрийн нэгдсэн бодлого, хууль тогтоомж, норм нормативын баримт бичгийг үндэслэн боловсруулсан төслийн сонгосон шийдэл, төслийг хэрэгжүүлснээр гарах үр дүнгийн талаарх тодорхой санал, дүгнэлт	Зураг төслийг хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа дараах норм, дүрмүүдийг баримтлан боловсруулсан байна. Үүнд: - ЗЗБНбД 22-004 -2016 "Авто зам төсөллөх" - БНбД 32-01-04 "Хотын зам төсөллөх" - БНбД 32-02-12 "Авто замын гүүр ба хоолой төсөллөх" - БНбД 81-25-07 "Авто замын барилгын төсвийн жишиг норм" - БНбД 81-28-07 "Төмөрбетон гүүр, хоолойн барилгын төсвийн жишиг норм" - ЗЗБНбД 81-013-2019 "Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөв бодох норм"
Эдийн засгийн үр ашиг, хөдөлгөөний аюулгүй байдал, экологийн хор хөнөөлгүй байдал, ашиглалтын үеийн найдвартай ажиллагаа, төсөвт өртгийн тооцооны талаарх дүгнэлт	Төсвийг орон тооны бус экспертүүд дараах байдлаар хянаж баталгаажуулсан байна. Үүнд: 13.45 км гол замын барилгын ажлын төсөв **98 073 321 272** төгрөг Холбоос 1.23 км /ПК0+060-ПК0+820/ авто замын барилгын ажлын төсөв **1 983 069 532** төгрөг Холбоос 1.23 км /ПК0+820-ПК1+230/ авто замын барилгын ажлын төсөв **2 460 388 779** төгрөг 24.9 у/м төмөрбетон гүүрийн төсөв **3 013 811 256** төгрөг 48 у/м төмөрбетон гүүрийн төсөв **10 646 117 685** төгрөг Цахилгааны шугам өндөрлөх ажлын төсөв **37 167 391** төгрөг Холбооны шугам хамгаалах ажлын төсөв **150 598 790** төгрөг Төсвийн нийт тооцоо, иж бүрдлийг хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа үнэ бүрдлийн норм, нормативын дагуу тооцсон болохыг хянаж, дүгнэв.

"Авто замын тухай" хуулийн 19 дүгээр зүйлийн 19.4, 19.5 дахь заалтад заасны дагуу Авто зам, замын байгууламжийн зураг төслийн алдааг зураг төсөл боловсруулсан байгууллага, зохиогч хариуцах ба зураг төслийн техникийн шийдэл болон төсөвт өртгийн тооцооны талаар гаргасан дүгнэлтийн алдааг магадлал хийсэн этгээд хариуцна.

Улаанбаатар-Мандалговь А0201 чиглэлийн замаас Сэргэлэн сум А25 чиглэлийн авто зам хүртэлх хатуу хучилттай авто замын инженерийн нарийвчилсан зураг төслийн баримт бичгийг холбогдох нормуудын шаардлагад нийцүүлэн төлөвлөсөн бөгөөд уг зураг төслөөр зам барилгын ажил гүйцэтгэх боломжтой гэж дүгнэж байна.

Тус зураг төслийн баримт бичигт "Зам, замын байгууламжийн зураг төсөлд магадлал хийх үйл ажиллагааг зохион байгуулах журам"-ын дагуу магадлалын ерөнхий дүгнэлт бичсэн болно.

ЗАМ ГЭЭ ... ГЭВ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУЛДВЭРИЙН ГАЗАР
ЭХ ХУВЬ
Д.Оюун
25 12 25

Улаанбаатар-Мандалговь А0201 чиглэлийн замаас Сэргэлэн сум А25 чиглэлийн авто зам хүртэлх хатуу хучилттай авто замын инженерийн нарийвчилсан зураг төслийн магадлалын ерөнхий дүгнэлт нь орон тооны бус экспертүүдийн гаргасан дүгнэлтийн хамт хүчинтэй. (Хавсралт: 24 хуудас)

"ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ" ТӨҮГ-ЫН ЗАХИРАЛ — Д.ОЮУНБОЛД

БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ, ЗУРАГ ТӨСЛИЙН МАГАДЛАЛ, СТАНДАРТ, НОРМ, НОРМАТИВЫН ХЭЛТСИЙН ДАРГА — Э.БАЛТ

БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ, ЗУРАГ ТӨСЛИЙН МАГАДЛАЛ, СТАНДАРТ, НОРМ НОРМАТИВЫН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН — С.МӨНХТУЯА

ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР
ЭХ ХУВЬ
Д.Оюун
25 12 25

Зураг төслийн баримт бичгийн
МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТИЙН ХАВСРАЛТ №1

ЗУРАГ ТӨСЛИЙН БҮРДЛИЙН ХЭСГИЙН НЭР, МАРК, ХУУДАСНЫ ТОО

Авто замын зураг төсөл, 100

2025 оны 12 сарын 17 өдөр

Д/д	Утга	Тайлбар
1	Обьектын нэр	УЛААНБААТАР-МАНДАЛГОВЬ А0201 ЧИГЛЭЛИЙН ЗАМААС СЭРГЭЛЭН СУМ А25 ЧИГЛЭЛИЙН АВТО ЗАМ ХҮРЭХ ХАТУУ ХУЧИЛТТАЙ АВТО ЗАМЫН ИНЖЕНЕРИЙН НАРИЙВЧИЛСАН ЗУРАГ
2	Обьектын байршил, хүчин чадал	Төв аймаг, Сэргэлэн сум
3	Зураг төслийн байгууллага	"Эм Ай Эл" ХХК
3. Дүгнэлтийн товч утга: /Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 204 дүгээр тогтоолын 7-р зүйлээс/		
4	9.9.1 авто зам, замын байгууламжийн байршил тогтоосон шийдвэр, зураг төсөл боловсруулах даалгавар, техникийн нөхцөл, холбогдох мэргэжлийн байгууллагатай зөвшилцсен байдал;	Төв аймгийн Засаг дарга Л. Төмөрчөдөрийн баталсан 2025 оны 04 дугаартай "Улсын чанартай А01-02 чиглэлийн замаас Сэргэлэн сумын чиглэлийн авто зам хүртэлх хатуу хучилттай авто замын ажлын зураг төсөл боловсруулах даалгавар", мөн даргын баталсан 2025 оны 07 дугаартай даалгаврыг шинэчилсэн байна. 1. Төв аймгийн Сэргэлэн сумын засаг даргын 2025 оны 02/210 дугаартай "Мэдэгдэл хүргүүлэх тухай" албан тоот: хөдөлгөөний 4 зурвастай, зорчих хэсэг зааглагдсан, тооцоот хурд 100км/ц-аас багагүй байх, явган зам төлөвлөх, гэрэлтүүлэгтэй байх гэсэн заалттай 2. МХС ХХК-ий гүйцэтгэх захирал Б. Мөнхбатын ШК-202506/04 дугаартай Техникийн нөхцөл: шилэн кабель хамгаалах, шилжүүлэх, худаг сувагчлал байгуулах тухай заалттай. 3. Жемнет ХХК-ийн Гүйцэтгэх захирал С. Дэлгэрсайханы баталсан Техникийн даалгавар: шилэн кабель хамгаалах, шилжүүлэх заалттай. 4. Скайнетворкс ХХК-ий Кабель сүлжээний албаны захирал Ц. Гантулгын баталсан Техникийн даалгавар: шилэн кабелийг шилжүүлэх, хамгаалалтад авах. 5. УБ Цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн Техникийн нөхцөл №01/03284/25 Ажлын зургийг дараах хүмүүстэй зөвшилцөж, баталгаажуулсан байна. Үүнд: 1. Төв аймгийн Засаг дарга Л. Төмөрчөдөр 2. Аймгийн ЗДТГ-ын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга Э. Уянга 3. Аймгийн ГХБХБ-ын БХБХ-ийн дарга, Ерөнхий архитектор Д. Алтансүх 4. Сэргэлэн сумын Засаг дарга Т. Гансүх

Д/д	Утга	Тайлбар
5	9.9.2. инженерийн шийдэл, бүтэц нь дагаж мөрдөж байгаа норм, дүрэм, стандарт, инженер-геологийн судалгааны дүгнэлт, техникийн нөхцөлийн дагуу зохиогдсон эсэх;	1. Инженер-геологийн судалгааг "Инжгеотех" ХХК гүйцэтгэж тайлан гаргаж, Улсын магадлалаар баталгаажуулсан байна. 2. Байрзүйн зураглалыг "Модун Артель групп" ХХК гүйцэтгэж, тайлан гаргасан байна.
6	9.9.3. авто зам, замын байгууламжийн чиглэл, байршил, төлөвлөлт, инженер-геологийн нөхцөл, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, сонгосон хувилбарын талаарх дүгнэлт;	Авто замын трассын хувилбарыг Захиалагч байгууллагатай зөвшилцөн дараах хүмүүс баталгаажуулсан байна. 1. Төв аймгийн Засаг дарга Л. Төмөрчөдөр 2. Төв аймгийн Ерөнхий архитектор Д. Алтансүх 3. Төв аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн дарга Э. Уянга 4. Төв аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга Б. Насанжаргал 5. Төв аймгийн Замын цагдаагийн тасгийн дарга, Цагдаагийн ахмад Н. Сундуйжав 6. Сэргэлэн сумын засаг дарга Т. Гансүх 7. Сэргэлэн сумын Газрын даамал Р. Жавзандолгор
7	9.9.4. хөдөлмөр хамгаалал, техникийн аюулгүй ажиллагаа, орчны эрүүл ахуйн байдалд тавигдах стандартын шаардлага болон норм, дүрмийг баримталсан байдал;	Хөдөлмөр хамгаалал, техникийн аюулгүй ажиллагааны талаар тайлбар бичигт нэмж бичих
	/Монгол улсын Засгийн газрын 108 дугаар тогтоолын 6 дугаар зүйлээс/	
8	6.12.3. барилга байгууламжийн гаднах ерөнхий төрх, архитектурыг хот төлөвлөлтийн шаардлагад нийцүүлэн орчны барилга байгууламжтай уялдуулсан байдал, эзэлхүүн болон талбайг үр ашигтай төлөвлөсөн байдал;	
9	6.12.5. барилгын ажлын зохион байгуулалтын болон барилга байгууламжийг буулгах, задлах ажил гүйцэтгэх зураг төсөлд хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны шаардлагыг тусгасан байдал.	
10	6.12.6. инженерийн шугам сүлжээний уртын дагуух төлөвлөлтийн оновчтой шийдэл;	Замтай огтлолцсон инженерийн байгууламжийг шилжүүлэх, хучитгэх, өндөрлөх зураг төсвийг "Пи юу ай" ХХК боловсруулж байгаа гэж тайланд дурьдсан байна.
11	6.12.7. хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажиллаж, амьдрах нөхцөлийг хангасан төлөвлөлтийн шийдлийг тусгасан байдал;	ХБИ-нд зориулсан налуу зам, хөтөч хавтан зэргийг ажлын зурагт тусгасан байна.
12	6.12.8 Магадлалын дүгнэлтэд хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийг үндэслэн төлөвлөлт, техникийн үндсэн шийдэл, эдийн засгийн үр ашигт мэргэжлийн үнэлэлт өгч, техник-эдийн засгийн үндэслэл, зураг төсөлд нэмж тусгах буюу хасах, өөрчлөх асуудлын талаар товч, тодорхой тусгана.	Хавсралт-2 үзэх.

Дүгнэлт бичсэн:

Эксперт № 11-01 /С.Батсүх/ .....

2025 оны 12 сарын 17 өдөр

CONSULTING ENGINEER Sakhiya 2022-2027

Зураг төслийн баримт бичгийн
МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТИЙН ХАВСРАЛТ №2

ЗУРАГ ТӨСЛИЙН БҮРДЛИЙН ХЭСГИЙН НЭР

Авто замын зураг төсөл

2025 оны 12 сарын 17 өдөр

Д/д	Утга	Тайлбар
1	Обьектын нэр	УЛААНБААТАР-МАНДАЛГОВЬ А0201 ЧИГЛЭЛИЙН ЗАМААС СЭРГЭЛЭН СУМ А25 ЧИГЛЭЛИЙН АВТО ЗАМ ХҮРЭХ ХАТУУ ХУЧИЛТТАЙ АВТО ЗАМЫН ИНЖЕНЕРИЙН НАРИЙВЧИЛСАН ЗУРАГ
2	Обьектын байршил, хүчин чадал	Төв аймаг, Сэргэлэн сум
3	Зураг төслийн байгууллага	"Эм Ай Эл" ХХК

Д/д	Экспертийн санал, илэрсэн алдаа зөрчил	Алдаа, зөрчлийг засаж, төсөлд засвар оруулсан тухай тайлбар, танилцуулга
1	Тодруулга: 1. Газрын захирамжийн талаар тайлбар ирүүлэх	Газрын захирамж хүсэх тухай 2025 оны 06-р сарын 03-ны өдрийн 101/25/MIL тоот албан бичгийг Төв аймгийн Сэргэлэн сумын засаг даргын тамгын газарт хүргүүлсэн билээ. / Тайлбар бичгийн Хавсралт №4-т/. Уг албан бичгийн хариу болгож 2025 оны 06-р сарын 03-ны өдрийн 02/180 тоот дугаартай Сэргэлэн сумын ЗДТГ-с албан бичиг ирүүлж ажлыг цааш үргэлжлүүл гэж чиглэл өгсөн. / Тайлбар бичгийн Хавсралт №5-т үзүүлэв/
2	Хучилтын тооцоо: 1. Хучилтын тооцоонд хөлдөлтийн гүнийг 1,38м гэсэн нь буруу. тухайн газрын хөрсний нөхцлөөс хамааруулж геологийн дүгнэлтээс авч, тооцоог шалгах	Хучилтын тооцоог дахин хянаж хөлдөлтийн гүнийг инженер геологийн тайлангийн улирлын хөлдөлтийн гүн IV-3 дугаар хүснэгтээс авч тооцоог нягтлав. Уг тооцооны өгөгдөл өөрчлөгдсөнөөр хүйтэн тэсвэрлэлтийн нөөц багассан боловч үр дүн эерэг хэвээр байна.
3	Тайлбар бичиг: 1. Хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдлын талаар авах арга хэмээний талаар бүлэг болгож оруулах 2. Хөдөлгөөн зохион байгуулалтын зурган дээр тэмдэг, тэмдэглэгээний талаар Замын цагдаагаас санал авах	1. Тайлбар бичигт 4-р бүлэг шинээр нэмж "Хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдал" талаар мэдээлэл заавар шаардлага зэргийг оруулав. 2. Төв аймгийн замын цагдаагийн тасгийн дарга, Цагдаагийн ахмад Н. Сундуйжав-д үзүүлж санал авч засварыг хийж гүйцэтгэв.

Д/д	Экспертийн санал, илэрсэн алдаа зөрчил	Алдаа, зөрчлийг засаж, төсөлд засвар оруулсан тухай тайлбар, танилцуулга
4	Гол замын ажлын зураг: 1. Хэвтээ муруйн хамгийн бага радиусыг 450м-ээр төлөвлөсөн байна. Нормын дагуу 600м-ээс багагүй байх ёстой. тайлбарлах 2. 0+240-0+700 хооронд 4м орчим өндөр далан төлөвлөснийг тайлбарлах 3. Хөдөлгөөн зохион байгуулалтын зураг дээрх гарцны хэсэгт гурвалжин аралын тэмдэглэгээ хийх 4. Буцаж эргэх уулзвар зүүн эгнээний өргөсөл гэсэн тэмдэг тавих 5. Буцаж эргэх тэмдгийг тусгаарлах зурвас дээр тавих 6. Олон зурвастай зам учраас эдгээр тэмдгийг П хэлбэрийн тулгуур дээр байрлуулах 7. Гарцны хурд шилжүүлэх зурвас дээр эгнээ салах, нийлэх тэмдэг тавих 8. Замын тэмдэг нь хашлаганаас 2м зайд байрлуулах гэсэн нь хэт хол байна. засах 9. Гэрэлтүүлэгтэй бол нэг маягийн хөндлөн огтлол, хөдөлгөөн зохион байгуулалтын зураг дээр харуулах 10. Эргэцийн хүснэгтийг нэмэх 11. Гарцны эргэлтийн радиус, уулзах өнцөг зэргийг үзүүлэх 12. Дагуу огтлол дээр хөрсний таних тэмдгийг оруулах 13. Тоо хэмжээг ирүүлэх	1. ПК 3+380 байрлалд ус зүйн зарцуулганы дагуу 48 урт/м төмөр бетон гүүр төлөвлөсөн. Уг гүүрийг БНбД 32.02.11 нормын дагуу "Гүүр хоолой байршуулах" бүлэгт заасан усны урсгалтай ташуугийн хэмжээ 10° илүүгүй байх заалт мөрдөж байрлуулсан. Гүүрийг шулуун хэсэгт байрлуулахын тулд муруйн радиусыг багасгасан. 600 м-г 450 м болгож бууруулсан хэсэгт хурдыг 50км/ц хүртэл бууруулахаар төлөвлөсөн. 2. 0+240-0+700 хооронд дагуу огтлолыг алдаатай төлөвлөсөн байсныг бууруулж засав. 3. Хөдөлгөөн зохион байгуулалтын зураг дээрх гарцны хэсэгт гурвалжин аралын тэмдэглэгээ хийв. 4. Буцаж эргэх уулзвар зүүн эгнээний өргөсөл гэсэн тэмдэг тавив. 5. Буцаж эргэх тэмдгийг тусгаарлах зурвас дээр тавив. 6. Олон зурвастай зам учраас эдгээр тэмдгийг П хэлбэрийн тулгуур дээр байрлуулав. 7. Гарцны хурд шилжүүлэх зурвас дээр эгнээ салах,нийлэх тэмдэг тавив. 8. Замын тэмдэг нь хашлаганаас 1.5м зайд байрлуулав. 9. Гэрэлтүүлэгтэй бол нэг маягийн хөндлөн огтлол,хөдөлгөөн зохион байгуулалтын зураг дээр харуулав. 10. Эргэцийн хүснэгтийг нэмэв. 11. Гарцны эргэлтийн радиус, уулзах өнцөг зэргийг үзүүлэв. 12. Дагуу огтлол дээр хөрсний таних тэмдгийг оруулав. 13. Тоо хэмжээг хүргүүлэв.
5	Холбоос замын ажлын зураг: 1. Гол замтай хэдэн градусаар огтлолцож байгаа вэ 2. Дагуу огтлолын эхэнд хугарал гарсныг засах 3. Дагуу огтлол дээр хөрсний зүсэлтийн таних тэмдгийг оруулах 4. Гол замтай адил засваруудыг хийх 5. Ажлын тоо хэмжээнд хатуу материалыг тэслэх, эсвэл гидромолот хэрэглэх эсэхээ тодорхой болгох 6. Трассын төгсгөлөөс гүүр хүртэлх хэсэгт хурдны хязгаарын тэмдэг тавих	1. Уулзварын бүлэг оруулав. 2. Дагуу огтлолыг засав. 3. Дагуу огтлол дээр таних тэмдэг оруулав. 4. Ажлын тоо хэмжээнд хатуу материалыг гидромолот хэрэглэхээр тусгав. 5. Трассын төгсгөлөөс гүүр хүртэлх хэсэгт хурдны хязгаарын тэмдэг байрлуулав.
6	Техникийн шаардлага: 1. Ямар битум хэрэглэх вэ. Битумын үзүүлэлтийн хүснэгтүүд хоосон байгааг бөглөх 2. Бетоны М маркыг В ангиар сольж, шахалтын бат бэхийг зөв бичих 3. Хольцыг халаах хэм, битумын марк зэргийг нөхөж бичих 4. Инженерийн хангамж, ЦБС гм хэрэглэгдэхгүй хэсгүүдийг хасах	1. Техникийн шаардалагыг засаж хянав.

Дүгнэлт бичиж, биелэлтийг шалгасан эксперт № 11-01 ..... /С.Батсүх/

2025 он 12 сар 17 өдөр

Биелэлтийн тайлбар бичсэн ..... /Б.Нямгэрэл/

2025 он 12 сар 24 өдөр

MONGOLIA 2011-42/013 CONSULTING ENGINEER BATSUKH Sakhiya 2023-2027

Зураг төслийн баримт бичгийн

МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТИЙН ХАВСРАЛТ №2

ТӨВ АЙМАГ, СЭРГЭЛЭН СУМ, УЛААНБААТАР -МАНДАЛГОВЬ ЧИГЛЭЛИЙН ЗАМААС СЭРГЭЛЭН СУМ А25 ЧИГЛЭЛИЙН АВТО ЗАМ ХҮРЭХ АВТО ЗАМЫН ИНЖЕНЕРИЙН НАРИЙВЧИЛСАН ЗУРАГ ТӨСӨЛ

/СЭРГЭЛЭН СУМЫН 4 ЭГНЭЭ БА 2 ЭГНЭЭ АВТО ЗАМД БАРИГДАХ ТӨМӨРБЕТОН ГҮҮРИЙН ЗУРАГ ТӨСӨЛ, ДУГААР:

2025 оны 12 сарын 05 өдөр

Д/Д	Утга	Тайлбар
1	Объектын нэр	Төв аймаг, Сэргэлэн сум, Улаанбаатар - Мандалговь чиглэлийн замаас сэргэлэн сум А25 чиглэлийн авто зам хүрэх авто замын инженерийн нарийвчилсан зураг төсөл. /Сэргэлэн сумын 4 эгнээ ба 2 эгнээ авто замд байрлах төмөрбетон гүүрийн зураг төсөл, дугаар:
2	Объектын байршил, хүчин чадал	Сэргэлэн сумын Авто замд байрлах гүүрүүд: • 2 эгнээ авто замд байрлах 24у/м төмөрбетон гүүрийн Г-8.0м, явган зам Т=1.5 м, дугуйн зам 1.5м өргөнтэй, 24.0м*1 схем бүхий 24.9 у/м авто замын гүүр. • 4 эгнээ авто замд байрлах 24у/м төмөрбетон гүүрийн 2Г-8.0м, явган зам Т=2.0 м, дугуйн зам 2.25м өргөнтэй, 24.0м*2 схем бүхий 48.95 у/м хос авто замын гүүр. Координат: Гүүр 1 (4эгнээ): Эхлэл:х-645347.985, у-5276200.654, төгсгөл:х-645368.790, у-5276244.962 Гүүр 2 (2 эгнээ): Эхлэл:х-648194.876,у-5277591.850, төгсгөл:х-648203.104, у-5277568.349
3	Зураг төслийн байгууллага	"Эм Ай Эл" ХХК

д/д	*Экспертийн санал, илэрсэн алдаа зөрчил*	*Алдаа, зөрчлийг засаж, төсөлд засвар оруулсан тухай тайлбар, танилцуулга*
1	Инженерийн дэлгэрэнгүй тайлан судалгааны тайлбар бичиг:	
1.1	Гүүрийн инженерийн тооцоо, судалгааны дэлгэрэнгүй тайлан ирээгүй, ирүүлэх	Гүүрийн инженерийн тооцоо, судалгааны дэлгэрэнгүй тайланг боловсруулж хүргүүлэв.
1.2	Гүүрийн үндсэн хэмжээг /гүүрэн гармын/ тооцоог инженерийн дэлгэрэнгүй тайланд хавсаргах. Энэ тооцоог ирүүлэх.	Гүүрийн үндсэн хэмжээг тодорхойлсон гүүрэн гармын тооцоог инженерийн тайланд хавсаргав.
1.3	Дам нуруу, тулгуурын бүтээцийн инженерийн тооцооллыг хийж, инженерийн тайлан судалгаанд хавсаргаж ирүүлэх	Дам нуруу, тулгуурын бүтээцийн инженерийн тооцооллыг инженерийн тайланд хавсаргав.
2	Зураг төсөлд:	
2.1	Зураг төслийн нүүр хийж, гарчиг, дугаарыг стандартын дагуу бичих	Зураг төслийн нүүр хийж, гарчиг, дугаарыг стандартын дагуу бичив. Зураг төслийн дугаар №
2.2	Зураг төслийн эхний хуудсанд гүүрэн байгууламжийн төлөвлөлт, үзүүлэлтийн талаар товч тайлбар оруулах	Гүүрэн байгууламжийн төлөвлөлт, үзүүлэлтийн талаар товч тайлбар хийж зураг төсөлд хавсаргав.
2.3	Гүүрийн хэвтээ байгуулалт дээр урсгал залах далангийн байгуулалтыг гүйцэд үзүүлэх	Урсгал залах далангийн төлөвлөлтийг нэмж оруулав.
2.4	Хуудас 5. Явах ангийн хучилтад ус тусгаарлах үеийн доод талд тэгшилгээний үеийг нэмж хийх	Тэгшилгээний үе бетоныг нэмж оруулав.
2.5	Гүүрийн хөндлөн огтлол дээр "хамгаалалтын үе бетон h=40мм" гэснийг хамгаалалтын арматурласан бетон үе h=40мм" гэж засаж бичих	Зохих ёсоор нь засаж өөрчлөв.
2.6	Явах ангийн хийцийн зургийг М1:50 масштабтайгаар хэсэгчлэн томсгож зурж нэмж оруулах	Явах ангийн хийцийн зургийг М1:50 масштабтайгаар боловсруулж зураг төсөлд хавсаргав.
2.7	Тулах хэсгийн даац болон маркийг нэмж тэмдэглэх	Тулах хэсгийн даац, маркийг нэмж оруулав.
3	**Техникийн шаардлага**	
3.1	Техникийн шаардлагыг зургийн даалгаварт заасан шаардлагын дагуу боловсруулж ирүүлэх	Техникийн шаардлагыг зургийн даалгаврын дагуу боловсруулан хавсаргав.

Дүгнэлт бичиж, биелэлтийг шалгасан:

Эксперт № 21-21-05 Самбуу Хаснавч /овог, нэр/.....

MONGOLIA CONSULTING ENGINEER KHASNAVCH Sambuu ЗЗИ-05-24

2025 он 12 сар 24 өдөр

Биелэлтийн тайлбар бичсэн:

Б.Ардах /овог, нэр/ .....

2025 оны 12 сар 24 өдөр

Зураг төслийн баримт бичгийн
МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТИЙН ХАВСРАЛТ №1

ЗУРАГ ТӨСЛИЙН БҮРДЛИЙН ХЭСГИЙН НЭР, МАРК, ХУУДАСНЫ ТОО

Гүүрийн зураг төсөл, TU-SE/25/006, 131

2025 оны 12 сарын 24 өдөр

Д/д	Утга	Тайлбар
1	Обьектын нэр	УЛААНБААТАР-МАНДАЛГОВЬ А0201 ЧИГЛЭЛИЙН ЗАМААС СЭРГЭЛЭН СУМ А25 ЧИГЛЭЛИЙН АВТО ЗАМ ХҮРЭХ ХАТУУ ХУЧИЛТТАЙ АВТО ЗАМЫН ИНЖЕНЕРИЙН НАРИЙВЧИЛСАН ЗУРАГ
2	Обьектын байршил, хүчин чадал	Төв аймаг, Сэргэлэн сум
3	Зураг төслийн байгууллага	"Эм Ай Эл" ХХК
3. Дүгнэлтийн товч утга: /Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 204 дүгээр тогтоолын 7-р зүйлээс/		
4	9.9.1 авто зам, замын байгууламжийн байршил тогтоосон шийдвэр, зураг төсөл боловсруулах даалгавар, техникийн нөхцөл, холбогдох мэргэжлийн байгууллагатай зөвшилцсөн байдал;	/Сэргэлэн сумын 4 эгнээ ба 2 эгнээ авто замд байрлах төмөрбетон гүүрийн зураг төсөл, дугаар: TU-SE/25/006 1. 2 эгнээ авто замд байрлах 24у/м төмөрбетон гүүрийн Г-8.0м, явган зам Т=1.5 м, дугуйн зам 1.5м өргөнтэй, 24.0м*1 схем бүхий 24.9 у/м авто замын гүүр. 2. 4 эгнээ авто замд байрлах 24у/м төмөрбетон гүүрийн 2Г-8.0м, явган зам Т=2.0 м, дугуйн зам 2.25м өргөнтэй, 24.0м*2 схем бүхий 48.95 у/м хос авто замын гүүр Координат: Гүүр 1: (4эгнээ): Эхлэл:х-645347.985, у-5276200.654,төгсгөл:х-645368.790, у-5276244.962 Гүүр 2 (2 эгнээ): Эхлэл:х-648194.876,у-5277591.850, төгсгөл:х-648203.104, у-5277568.349 Төв аймгийн засаг дарга Л.Төмөрчөдөрийн баталсан 2025 оны 05 сарын 29-ны өдрийн №07 тоот ажлын даалгавар Захиалагч “Сэргэлэн сумын засаг даргын тамгын газар Байр зүйн зураглал, геодезийн судалгааг “Модун Артель групп” ХХК, , инженер Б.Баттулга Геологийн судалгааг “Инжгеотех” ХХК, инженер Э.Хүчбаяр, захирал Л.Ганзориг Ус зүйн судалгааны ажлын тайлан, зөвлөх инженер Л.Дашдорж, усны мэргэшсэн инженер Х.Бадарч Инженерийн тооцоо, зургийг хянасан Б.Нямгэрэл Зургийн инженер Б.Ардах Зургийг гүйцэтгэсэн Ж.Эрболат
5	9.9.2. инженерийн шийдэл, бүтэц нь дагаж мөрдөж байгаа норм, дүрэм, стандарт, инженер-геологийн судалгааны дүгнэлт, техникийн нөхцөлийн дагуу зохиогдсон эсэх;	Төв аймгийн засаг дарга Л.Төмөрчөдөрийн баталсан 2025 оны 05 сарын 29-ны өдрийн №07 тоот ажлын даалгавар Ус зүйн тооцоо, геологийн судалгаа ЗЗБНбД 22-004-2016 Авто зам төсөллөх БНбД 32-02-12 Авто замын гүүр ба хоолой төсөллөх болон бусад холбогдох норм дүрэм

Д/д	Утга	Тайлбар
6	9.9.3. авто зам, замын байгууламжийн чиглэл, байршил, төлөвлөлт, инженер-геологийн нөхцөл, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, сонгосон хувилбарын талаарх дүгнэлт;	Гүүрийн төлөвлөлтийг Захиалагчаас өгсөн зургийн даалгаврын дагуу болон "АВТО ЗАМЫН ГҮҮР БА ХООЛОЙ ТӨСӨЛЛӨХ" БНбД 32.02.12 –ийн дагуу тавигдах шаардлагыг бүрэн хангахаар зураг төслийн ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд: Сэргэлэн сумын Авто замд байрлах гүүрүүд нь Туул голын ус хураах талбай, Зүүндэлгэр, Өгөөмрийн амнаас орж ирэх улирлын чанартай урсацтай горхи, үерийн урсацтай хуурай сайрууд дээр байрлана. 1. Усны урсгал их явагдах дараах 2 хэсэгт гүүрүүдийн төлөвлөсөн. Үүнд: Гүүр 1: ПК3+350 ба ПК3+410, Гүүр 2: ПК1+037.55-аас ПК1+062.45 1. Гүүр 1: 2 эгнээ авто замд байрлах 24у/м төмөрбетон гүүрийн Г-8.0м, явган зам Т=1.5 м, дугуйн зам 1.5м өргөнтэй, 24.0м*1 схем бүхий 24.9 у/м авто замын гүүр. 2. Гүүр 2: 4 эгнээ авто замд байрлах 24у/м төмөрбетон гүүрийн 2Г-8.0м, явган зам Т=2.0 м, дугуйн зам 2.25м өргөнтэй, 24.0м*2 схем бүхий 48.95 у/м хос авто замын гүүр. 3. Гүүрийн алгаслын уртыг нэг маягийн жигдрүүлсэн байхаар 24 м-ийн урттай төмөрбетон дам нуруу сонгон, зорчих хэсэгт нэг талын хөндлөн хэвгийтэй, 22см зузаан төмөрбетон хавтан сонгосон. Дам нурууны өндрийг 1.6 м байхаар төлөвлөсөн. 4. Хучилтын өнгө үе асфальтбетон 10 см 5. Гүүрэн доорх овор хэмжээг: Гүүр 1: ТИУТ 1393.548 үед 0,561м байхаар төлөвлөсөн Т Гүүр 2: ТИУТ 1422.366 үед 1.783 м байхаар төлөвлөсөн. 1. Газар хөдлөлтийн 6-7 балл. Хур тунадас нь аадар шинжтэй тул үерлэх эрсдэл өндөртэй.Уур амьсгалын нөхцөлөөр Уулын завсар хоорондын тал хээрийн дэд бүс IIB бүсэд байрлана 2. Үндсэн Авто замын зурвас талбай уулын хөндийн хуримтлал-зөөгдлийн болон элэгдлийн хэв шинжит гадаргууд хамаарна. Хөрс нь дөрөвдөгч голоцены настай, аллюви- пролювийн гаралтай элсэн чигжээстэй хайрга, шавранцар, хайргархаг шавранцар хөрсөөр хучигдсан ангилагдаагүй Девоны настай, Горхи формацын тунамал гаралтай алевролит бүрдүүлнэ. Шавранцар хөрс нь овойлттой хөрсөнд нормчлогдсон. 3. Геологийн төвөгтэй нөхцөлтэй ба Геоморфологийн хэв шинжийн хувьд голын хөндийн зөөгдөл хуримтлалын хэв шинжит гадаргууд хамаарна. 4. Цочир хүйтрэлт, цасан болон шороон шуурганы давталт ихтэй. Гадаргуугийн өндержилт 1500 -1700 м хоорондх хэлбэлзэнэ. 5. Геологийн үзэгдлийн хувьд хур борооны үертэй үед гадаргуун угаагдал, хүйтний улиралд халиа тошин хөгжих боломжтой. ПК3+350 ба ПК3+410
7	9.9.4. хөдөлмөр хамгаалал, техникийн аюулгүй ажиллагаа, орчны эрүүл ахуйн байдалд тавигдах стандартын шаардлага болон норм, дүрмийг баримталсан байдал;	1. Авто зам төсөллөх ЗЗБНбд 22-004-2016, 2. "Барилгад хэрэглэх уур амьсгалын ба геофизикийн үзүүлэлтүүд" БНбД 2.01.01 3. "Авто замын гүүр ба хоолой төсөллөх" БНбД 32.02.11 4. Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх барилгын норм ба дүрэм" БНбД22.01.01*/2006 5. Хүнд даацын автотээврийн хэрэгсэл, Техникийн ерөнхий шаардлага MNS6278:2011 6. Замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага MNS 4596:2014 7. Замын тэмдэглэл. Техникийн ерөнхий шаардлага MNS 4759:2014
	/Монгол улсын Засгийн газрын 108 дугаар тогтоолын 6 дугаар зүйлээс/	

Д/д	Утга	Тайлбар
8	6.12.3. барилга байгууламжийн гаднах ерөнхий төрх, архитектурыг хот төлөвлөлтийн шаардлагад нийцүүлэн орчны барилга байгууламжтай уялдуулсан байдал, эзэлхүүн болон талбайг үр ашигтай төлөвлөсөн байдал;	Үнэлэх шаардлагагүй
9	6.12.5. барилгын ажлын зохион байгуулалтын болон барилга байгууламжийг буулгах, задлах ажил гүйцэтгэх зураг төсөлд хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны шаардлагыг тусгасан байдал.	Шаардлагагүй
10	6.12.6. инженерийн шугам сүлжээний уртын дагуух төлөвлөлтийн оновчтой шийдэл;	Инженерийн шугам сүлжээ байхгүй, шаардлагагүй
11	6.12.7. хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажиллаж, амьдрах нөхцөлийг хангасан төлөвлөлтийн шийдлийг тусгасан байдал;	Явган зам ба дугуйн зам төлөвлөсөн. Шаардлага хангасан
12	6.12.8 Магадлалын дүгнэлтэд хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийг үндэслэн төлөвлөлт, техникийн үндсэн шийдэл, эдийн засгийн үр ашигт мэргэжлийн үнэлэлт өгч, техник-эдийн засгийн үндэслэл, зураг төсөлд нэмж тусгах буюу хасах, өөрчлөх асуудлын талаар товч, тодорхой тусгана.	Магадлалын ерөнхий дүгнэлтийн хавсралт №2-д тусгасан шүүмжийн дагуу зураг төсөлд засвар хийсэн байна. БНбД ба бусад холбогдох норм дүрэм, шаардлагуудад нийцэж байгаа тул энэхүү зургаар барилгын ажил гүйцэтгэх боломжтой.

Дүгнэлт бичсэн:

Эксперт № 21-21-05 /С.Хаснавч/ ..... 2025 оны 12 сарын 24 өдөр

MONGOLIA CONSULTING ENGINEER KHASNAVCH Sambuu ЭЗИ-05-24

Зураг төслийн баримт бичгийн
МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТИЙН ХАВСРАЛТ №1
ЗУРАГ ТӨСЛИЙН БҮРДЛИЙН ХЭСГИЙН НЭР, МАРК, ХУУДАСНЫ ТОО

УЛААНБААТАР-МАНДАЛГОВЬ А201 ЧИГЛЭЛИЙН ЗАМААС СЭРГЭЛЭН СУМ ЧИГЛЭЛИЙН АВТО ЗАМ ХҮРЭХ 11.2 км АВТО ЗАМЫН АЖЛЫН ЗУРАГ

2025 оны 07 сарын 29 өдөр

Д/Д	Утга	Тайлбар
1	Объектын нэр	Улаанбаатар-Мандалговь А201 чиглэлийн замаас Сэргэлэн сум чиглэлийн авто зам хүрэх авто зам
2	Объектын байршил, хүчин чадал	Улаанбаатар-Мандалговь А201 чиглэлийн замаас Сэргэлэн сум чиглэлийн авто зам хүрэх 11.2 км авто замын ажлын зураг
3	Зураг төслийн байгууллага	Авто зам, гүүрийн зураг төслийн "Эм Ай Эл" ХХК
3. Дүгнэлтийн товч утга: /Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 168 дугаар тушаалын 9 дүгээр зүйлээс/		
4	9.9.1 авто зам, замын байгууламжийн байршил тогтоосон шийдвэр, зураг төсөл боловсруулах даалгавар, техникийн нөхцөл, холбогдох мэргэжлийн байгууллагатай зөвшилцсөн байдал;	Авто замын зураг төслийн "Эм Ай Эл" ХХКомпани болон Төв аймгийн Сэргэлэн сумын Засаг даргын тамгын газар хооронд байгуулсан Улаанбаатар-Мандалговь А201 чиглэлийн замаас Сэргэлэн сум чиглэлийн авто зам хүрэх 11.2 км хатуу хучилттай авто замын инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах гэрээ
5	9.9.2. инженерийн шийдэл, бүтэц нь дагаж мөрдөж байгаа норм, дүрэм, стандарт, ус зүйн судалгааны дүгнэлт, техникийн нөхцөлийн дагуу зохиогдсон эсэх;	а/ Ус зүйн тодорхойлолтыг тооцоолох норм ба дүрэм" БНбаН 2.01.14-86 б/ бусад холбогдох техникийн нөхцөл, норм дүрэм, стандартуудын дагуу ус зүйн судалгаа, тооцоог хийж гүйцэтгэсэн байна.
6	9.9.3. авто зам, замын байгууламжийн чиглэл, байршил, төлөвлөлт, ус зүйн нөхцөл, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, сонгосон хувилбарын талаарх дүгнэлт;	Улаанбаатар-Мандалговь А201 чиглэлийн замаас Сэргэлэн сум чиглэлийн авто зам хүрэх 11.2 км авто замын ус өнгөрөөх барилга байгууламжуудад ирэх хуурай сайруудын усзүйн тооцоо, дүгнэлтүүдийг хийж гүйцэтгэсэн
7	9.9.4. хөдөлмөр хамгаалал, техникийн аюулгүй ажиллагаа, орчны эрүүл ахуйн байдалд тавигдах стандартын шаардлага болон норм, дүрмийг баримталсан байдал;	Хайгуул судалгааны ажлын хүрээнд хөдөлмөр хамгаалал, техникийн аюулгүй ажиллагааг мөрдөж ажилласан
/Монгол улсын Засгийн газрын 108 дугаар тогтоолын 4,6 дугаар зүйлээс/		
